



## ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 30-ны өдөр

Дугаар 08

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын VIII хурал 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 20:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 27 гишүүд оролцохоос 22 гишүүнтэй 81.5% ирцтэй хуралдав.

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

- 1.Коронавирусийн халдварын нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Эрүүл мэндийн газрын мэдээллийг сонсох,
2. Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн II хуралдаанаас өгсөн үүргийг танилцуулах,
3. “Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн тэргүүн дэд захирлын хилийн Баянхошуу боомтоор газрын тосны бүтээгдэхүүн ачсан тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлж өгөх тухай саналын дагуу холбогдох шийдвэрийг гаргах.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Хилийн Баянхошуу боомт дээр байгаа газрын тосны бүтээгдэхүүний ачилт хийгдсэн 84 тээврийн хэрэгслийн Монгол жолооч нар өөрсдөө зөвшөөрсөн тохиолдолд үндсэн жолоочтой автомашиныг ариутгал, халдваргүйтгэлийн хяналтан дор зөвхөн 1 удаагийн тээвэрлэлтийг хилээр нэвтрүүлэхийг,

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
А.Нансалмаа, сумдын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал,  
аймгийн ахмадын хорооны дарга нарт:

- 1.Монголын уламжлалт Сар шинийн баярыг зөвхөн гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг нийт иргэдэд уриалж, бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд, нутгийн зөвлөл, хамт олны зохион байгуулалттай золголт хийхгүй байх талаар холбогдох арга хэмжээ авахыг;
- 2.Төрийн байгууллагын шуурхай хуралдаанаар нийт ажилтан, алба хаагч нарт Сар шинийн баярыг гэр бүлийн хүрээнд тэмдэглэх талаар мэдээлэл хүргэж, уриалга гаргах;

Биеийн тамир, спортын газрын дарга Б.Чимиддорж, Сумдын

Засаг дарга нарт:

- 1.Цагаан сарын хүчит бөхийн барилдаан, морин уралдааныг зохион байгуулахгүй байхыг;

Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар,

Дорнод аймгийн Авто тээврийн төвийн дарга нарт:

1. Хот хооронд болон нийтийн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарт халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг гаргаж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг;

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Мөнхтуяа,

Хил хамгаалах байгууллагын дарга нарт:

1. Коронавирусийн халдвар бүртгэгдсэн голомтын бүс нутгаас хүнсний бараа, бүтээгдэхүүнийг хилээр оруулахгүй байхад анхаарч, гарал үүслийн бичиг баримтыг сайтар шалгаж, хяналт тавьж ажиллахыг;

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаад:


1. Эмнэлгийн байгууллагын бэлэн байдлыг хангуулж, шаардлагатай тохиолдолд эмч нарыг дайчлан ажиллуулахыг;

2. Халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр хилийн боомтуудад ажиллаж байгаа мэргэжлийн байгууллагуудын алба хаагчдын 1 удаагийн хамгаалах хэрэгслийн нөхөн хангалтын тооцоо, судалгааг гаргаж, зохион байгуулахыг;

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Баяржаргалд:

1. Аймгийн хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгсэл болон хүнсний бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл гарч буй эсэхэд хяналт тавих ажлын хэсгийн мэдээллийг аймгийн Онцгой комиссын IX хуралдаанаар танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН  
ОРЛОГЧ ДАРГА  Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА